зургийг элэгдлээс хамгаалдаг. Хэрэв танхимд ашиглах бол ажлын зураг нь танхимын ширээний хэлбэр хэмжээтэй тохирч байх хэрэгтэй. Газар орон дээр ажиллах үед ажлын зургийг офицер цүнхний хэмжээтэй тохируулж эвхэх нь зохимжтой. Зургийн нугалсан хэсгийн номын хуудастай адил жигд эргүүлэн үзэхэд бүрэн дэлгэрэхгүйгээр ажиллахад тохиромжтой болсон байх ёстой. Зургийн наалтыг дайруулан эвхэж болохгүй. Нягт нямбай эвхсэн зураг нь ажиллахад эвтэй бөгөөд удаан хугацаанд ашиглах боломжтой.

*ХСИС-ийн Удирдлагын сургуулийн*
*821 дүгээр дамжааны сонсогч,*
*дэд хурандаа Б.Сайнболор*

## ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ГАДААД ХЭЛНИЙ МЭРГЭЖИЛТЭН БЭЛТГЭХ ҮЙЛ ЯВЦЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

***"Хэлтэй бол хөлтэй "***
*Монгол ардын зүйр цэцэн* үг

Дэлхий дахинд даяаршлын үйл явц эрчимжиж улс орон, байгууллага, хамт олон төдийгүй албан тушаалтнууд хоорондоо улам бүр харилцан хамааралтай болж, энэхүү үйл явцын хүрээнд орон орны хүмүүс хоорондын харилцаа идэвхитэй хөгжихийн сацуу дэлхий дахинд түгээмэл ашиглагдаж байгаа гадаад улсын аль нэг хэлийг ашиглаж байна. Улс орны хөгжил дэвшлийг дагаад байгууллагын үнэлэмж, чанар чансаа нь тухайн байгууллагад ажиллаж буй албан хаагч, хувь хүний мэдлэг боловсрол, ур чадвараас ихээхэн хамааралтай байх болов. Энэхүү урган гарч буй шаардлага нь өдрөөс өдөрт шинэ агуулга хэлбэрээр улам баяжиж, үүнийг дагаад аливаа байгууллагын хүний нөөцийн бодлогод маш ихээр хамааралтай болж байгаа нь бидэнд илт мэдрэгдэх болжээ.

Тавигдаж буй уг шаардлагыг хангаж, орчин үетэйгээ хөл нийлүүлэн алхахад шаардагдах мэдлэг боловсрол, мэдээллээр хангагдан өөрийгөө хөгжүүлэх, улмаар байгууллага, хамт олны ололт, амжилтыг бататгахын тулд зайлшгүй эзэмшсэн байх мэдлэг, боловсролын нэг нь гадаад хэл болж байгаа юм. Манай ард түмний дунд яригддаг "Хэлтэй бол хөлтэй" гэх -үг нь үүний нэгэн илрэл болж өнөөдөр биелэлээ олж байгаа нь та бидэнд өдрөөс өдөрт улам хүчтэйгээр мэдрэгдэх боллоо. Энэ үг гарцаагүй үнэн болох талаар гадаад улс, оронд зорчиж үзсэн хүн бүрээс уншигч эрхэм та ямар нэг хэмжээнд дуулсан биз ээ. Гадаад хэл сурахад арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс, цол, албан тушаал ямар ч ялгаагүй шүү дээ. Гагцхүү тухайн хүний өмнөө тавьсан зорилго, хувийн зохион байгуулалт, өөрийн мэдрэмж, чинхүү хүсэл сонирхол л үүнд хамаатай. Өнөө цагт гадаадад төрөл бүрийн, төрөл мэргэжлийн чиглэлээр энгийн болон цэргийн мэргэжлийн сургуулиудад янз бүрийн хугацаагаар суралцах боломжтой болжээ. Энэ нь тухайн хүнд төдийгүй харъяалагдах байгуулагад нь ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт болдог. Үүнд зөвхөн гадаад хэлийг сайтар эзэмшсэн байх асуудал л тавигдах гол шаардлага болдог билээ.

Энэхүү өгүүлэлдээ би ямар нэг хэлний тухай онцолж үзэхийг урьтал болгосонгүй, харин тухайн сурах хэлийг бусдын дэмжлэг туслалцаатайгаар болон биеэ дайчлан идэвхитэйгээр өөрийн болгох асуудлыг үр дүнтэй болгох боломж бидэнд байгаа тухай асуудлыг хөндөн тавьж байгаа юм.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хэдийгээр хэд хэдэн газарт гадаад хэлний мэргэжилтэн бэлтгэж байгаа хэдий боловч өнөөгийн байгууллагын хүний нөөцийн хөгжилд тавигдах шаардлага, суралцагсдын чанар байдал нь хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байгаа юм. Мөн үүнийг бичигч миний бие бээр англи хэлний хэд хэдэн шатны сургалтанд хамрагдаж тодорхой хэмжээнд суралцсан бөгөөд Хил хамгаалах ерөнхий газарт хэсэг хугацаанд англи хэлний багшаар ажиллаж байсны хувьд энэ асуудалд анхаарал хандуулж явдаг нэгэн юм.

Энэхүү ажлыг байгууллагын хүрээнд авч үзвэл тусгайлсан хөтөлбөр, заавар боловсруулан, хэрэгжилтийг ханган ажилласнаар үр дүнд хүрэх нь ойлгомжтой юм. Миний бие Хил хамгаалах байгууллагын хэмжээнд гадаад хэлний мэргэжилтэн бэлтгэх үйл ажиллагааг идэвхжүүлэх хэд хэдэн санааг дэвшүүлэхээр оролдлоо.

Үүний тулд ерөнхий хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалт, байгууллагын дотоод орлогыг тодорхой хэмжээнд ашиглах болон гадаадын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, түүнд хүмүүсээ өргөнөөр хамруулах зэрэг арга хэмжээ авах боломж бидэнд байгаа нь бахархууштай. Гагцхүү энэ боломжийг цаг алдалгүй үр дүнтэйгээр ашиглах асуудлыг бид анхааралдаа авах шаардлагатай байгаа юм.

Хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд хэлний сургалт ямар хэмжээнд явагдаж байгааг энгийн судалгааны жишээн дээр авч үзвэл:

***Зэвсэгт хүчин*** ЗХЖШ, БХИС-д 1995 оноос эхлэн гадаад хэлийг англи, орос, хятад, герман хэл, 2000 оноос турк хэл заах хэлбэрээр явуулж эхэлсэн бөгөөд дээрх 2 газарт гадаад хэл суралцагсдын тоо 3000 хол давсан судалгаа байдаг.Тэдний туршлагаас харахад анхан, дунд шатны сургалтыг гол төлөв дотооддоо явуулж, дээд, гүнзгий шатны сургалтыг өндөр шалгуураар шалгасны үндсэн дээр гадаад, дотоодын сургалтад хамруулан сургахаас гадна тухайн хэлний чиглэлээр өндөр түвшинд бэлтгэгдсэн мэргэжлийн багш урих хэлбэрээр явуулж байна.

***Хил хамгаалах байгууллага*** нь гадаад хэлний сургалтыг АНУ, БНЭУ-д англи хэлний, ХХЕГ, ХСИС-д орос, хятад, англи хэлний чиглэлээр тус тус 3 хүртэл сарын хугацаатайгаар бүрэлдэхүүнээ сургаж бэлтгэдэг.

ХХЕГ-т 2005 онд АНУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр англи хэлний иж бүрэн кабинет, сурах бичгийн хамт хүлээн авч суурилуулсан бөгөөд мөн тус улсын зардлаар 2 хүнийг англи хэлний мэргэжлийн багшаар АНУ-д бэлтгэжээ. Уг танхимд англи хэлний сургалтыг 2006 оноос эхлэн ХХЕГ болон хилийн отряд, ангиудын офицер, ахлагч нарт зохион байгуулж эхэлсэн байна. Түүнээс гадна ХЦДС /хуучнаар/, ХСИС-ийн Хилийн албаны сургуульд 3 сарын хугацаатайгаар гадаад хэлний дамжаа хичээллэж байгаа хэдий боловч хангалттай хэмжээнд хүрч чадахгүй байгаа юм. Судалгаанаас үзвэл 2000 оноос хойш дээрх дамжаануудад нийт 300 гаруй хүн зөвхөн анхан, дунд шатны дамжаанд суралцсан байна. Өөрөөр хэлбэл дээд болон гүнзгий шатны дамжаанд хүн суралцаагүй буюу тийм боломж гараагүй эсвэл шаардлага хангах хүн гараагүй гэсэн үг.

***Цагдаагийн байгууллага*** алба хаагчдынхаа гадаад хэлний мэдлэгийг ХСИС-ийн англи, хятад, орос хэлний дамжаанд жил бүр 30 гаруй хүн бэлтгэхээс гадна БХИС, ЗХЖШ-ын гадаад хэлний сургалтын төвтэй нягт хамтран ажиллаж 2-3 хүнийг дээд болон гүнзгий шатны дамжаанд сургадаг байна.

***Онцгой байдлын ерөнхий газар*** нь өөрийн хөрөнгөөр гадаад хэлний танхим байгуулан жил бүр 20-30 хүнийг англи хэлний анхан шатны дамжаанд, ХСИС-ийн гадаад хэлний тэнхимийн англи, хятад, орос хэлний дамжаанд жил бүр 20 гаруй хүнийг бэлтгэдэг бөгөөд ЗХЖШ-ын англи хэлний дээд болон гүнзгий шатны дамжаанд хүн сургах боломжийг эрэлхийлэн ажилладаг байна.

**Дэвшүүлж буй асуудлууд**

***Нэг.*** Гадаад хэлний сургалтыг анхан, дунд, дээд, гүнзгий гэсэн шатанд авч үздэг бөгөөд бусад байгууллагын туршлагаас ажиглан дүгнэхэд анхан, дунд шатны сургалтуудыг дотооддоо явуулах нь зардал багатай бөгөөд хялбар хийгдэж болох арга хэмжээ юм. Иймд анхан, дунд шатны сургалтыг тус бүр 3 сарын хугацаатай эрчимтэйгээр зохион байгуулж, дээд болон гүнзгий шатны мэргэжилтэнг тусгай шалгуурын үндсэн дээр гадаад улсад бэлтгэх нь зүйтэй юм.

Тиймээс бид:

- Одоо явагдаж байгаа сургалтуудыг ашиглан мэргэжилтэн бэлтгэх үйл явцыг чанаржуулах, суралцах хүний сонголтыг оновчтой болгох;
- ЗХЖШ, БХИС болон бусад гадаад хэлний сургалт явуулдаг сургуулиудын материаллаг баазыг ашиглах, хамтран ажиллах боломжийг бий болгох;
- Багшлах бүрэлдэхүүн болон сургалтын материаллаг баазыг өргөтгөх;
- Гадаад хэлний төрөлжсөн, хосолсон сургалтад бүрэлдэхүүнээ хамруулах;
- ХХЕГ-ын гадаад хэлний танхимын материаллаг баазыг өргөжүүлэх;
- Албан хаагчдын албан тушаалын шалгуур үзүүлэлт болгох, бодитойгоор шаардах зэрэг арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлага урган гарч байна.

***Хоёр.*** Хүний нөөцийн менежментийн үр дүнтэй арга хэлбэрүүдийн нэг болох шагнал урамшууллын системд гадаад хэлний сургалт, мэдлэгийн талаар тусгах нь зүйтэй асуудал юм. Энэ талаар ОХУ, ХБНГУ, БНБУ, Украйн зэрэг улсуудын цэрэг, арми, зарим төрийн байгууллагын албан хаагчид өөрийн гадаад хэл сурч эзэмшсэн тохиолдол бүртээ үндсэн цалингийн 5%-ийн урамшуулал авдаг байна. Өөрөөр хэлбэл нэг хэл сурсан бол 5, хоёр хэл бол 10 хувь гэх мэтээр өснө гэсэн үг. Энэ асуудал нь тухайн хүндээ гадаад хэл сурах сэдэл, сонирхол төрүүлэхээс гадна сэтгэлгээний урамшил өгч байгаа чухал арга хэмжээ юм. Түүнээс гадна амьжиргааныхаа эх үүсвэр болсон цалин хөлсөө нэмэгдүүлэхийн тулд хүмүүсийн хооронд гадаад хэл сурах өрсөлдөөн бий болно гэсэн үг юм.

***Гурав.*** Хил хамгаалах байгууллагын хувьд жил бүр тодорхой хэмжээнд хөрөнгө оруулалт хийгддэг бас нэгэн томоохон арга хэмжээ бол энхийг дэмжих ажиллагаа юм. Энхийг дэмжих ажиллагаа нь оролцож байгаа цэргийн алба хаагчийг олон талаар хөгжүүлэх үндэс суурийг тавьж өгдөг бөгөөд гадаад хэлний мэдлэгийг нь тодорхой түвшинд дээшлүүлж гадаад хэл сурахын ач холбогдлыг ойлгож, цаашид гүнзгийрүүлэн сурах сэдэл төрүүлдэг нь судалгаанаас ажиглагддаг. Иймд олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцсон офицер, ахлагч нарын чадварыг хөхүүлэн дэмжих, гадаад хэл сурах чиглэлээр тодорхой үүрэг чиглэлээр хангах,

тэднийг дараа дараагийн шатны сургалтуудад ээлж дараагаар хамруулан мэдлэг боловсролыг нь дээшлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай байгаа юм.

**Цаашид бид ямар арга хэмжээ авах нь үр дүнтэй вэ?**

1. Суралцагч байгууллага болох зорилт тавьж бие бүрэлдэхүүний гадаад хэл сурах идэвхийг төрүүлэхэд онцгой анхаарч, орчин нөхцлийг бүрдүүлэх.
2. Гадаад хэл сурах төрөл бүрийн хөшүүрэг ашиглах. Жишээ нь: Сурсан гадаад хэлний төрөл тутамд 5%-иас доошгүй цалингийн урамшуулал олгох, гадаад хэл сурах зорилготой хүмүүсээ дэмжих, ажлаас цалинтай чөлөө олгох гэх мэтийн хөнгөлөлт эдлүүлэх. Харин дээр дурдсан урамшуулал, хөнгөлөлт олгосны эцэст тавигдах шаардлагыг өндөржүүлж, хил хамгаалах байгууллагын гадаад хэлний сургалт болон мэдлэг /хүрсэн байх түвшингийн/-ийнстандарт тогтоох.
3. Хил хамгаалах байгууллагаас энхийн дэмжих болон олон улсын бусад ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний оролцооны төрөл, хэмжээг нэмэгдүүлэх замаар бүрэлдэхүүний гадаад хэлний мэдлэгийг дээшлүүлэх.
4. Байгууллагаас нэгдсэн бодлогоор зохицуулалт хийх арга хэмжээний хүрээнд байгууллагын зорилго, зорилтууддаа гадаад хэл сурах ажиллагааны талаар тусгах. Уг үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд байгууллагын хэмжээнд гадаад хэлний тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх.
5. Байгууллагын гадаад харилцааг өргөжүүлэх замаар бие бүрэлдэхүүнийг гадаад оронд хэлний чиглэлээр сургах боломжийг тогтмол эрэлхийлж, энэ чиглэлээр бусад орны сургуулиудтай хамтын ажиллагаагаа идэвхжүүлэх.
6. Хил хамгаалах байгууллагын бүх шатанд /ХХЕГ, Хилийн отряд, анги, застав гэх мэт/ гадаад хэл сурах үйл ажиллагааг хөгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч, хөхүүлэн дэмжих.
7. Албан тушаалын шалгуур үзүүлэлтэд гадаад хэлний асуудлыг тусгаж, бодитойгоор хэрэгжүүлэх.
8. Гадаад хэлний мэдлэг боловсролтой бүрэлдэхүүн болон энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургууль, дамжаадын хооронд тогтмол уралдаан тэмцээн зохион байгуулах, сурталчлах.
9. Бүх төрлийн мэдээллийн эх сурвалжийг өргөн ашиглах зэрэг болно.

**Хүрэхээр тосөолж буй үр дүн буюу дүгнэлт**

> Гадаадын энгийн болон цэргийн төрөл мэргэжлийн их, дээд сургуулиудад суралцах, тусгай мэргэжлийн урт, богино хугацааны дамжаа, сургалтууд болон олон улсын хурал, зөвлөгөөнд оролцох гадаад хэлтэй мэргэжилтний хангалттай нөөц бий болно.

> Цэргийн мэргэжлийн сургуульд суралцах бүрэлдэхүүнийг илгээх асуудлыг шийдвэрлэхэд хялбар болж, сургалтын үр дүн дээшилнэ.

> Энхийг дэмжих ажиллагаанд оролцох, оролцоо, төрлийн хувьд бусад байгууллагын бүрэлдэхүүнтэй өрсөлдөхүйц нөөц бий болно.

> Хүмүүсээ сургаж бэлтгэснээр байгууллагын зорилт хэрэгжих үйл явцад маш чухал нөлөө үзүүлэх бөгөөд үүнтэй холбоотойгоор албанд шаардагдах шинэ мэдээ, мэдээллээр цаг алдалгүй хангагдах нөхцөл бүрдэнэ.

> Бусад орны орны туршлагаас судлах, өөрийн туршлагаа сурталчлах боломж нөхцөл бүрдэнэ.